

ҮНДСЭН АЖИЛТНЫ ВИЗ (技術人文知識国際業務)

Техник технологи Хүмүүнлэг Олон улсын үйл ажиллагаа Үндсэн ажилтны виз

Энэхүү виз-ний нөхцөл нь Байгалийн шинжлэх ухаан, Хүмүүнлэгийн ухааны мэдлэг эзэмшсэн гадаадын иргэн тухайн мэргэжилтэйгээ уялдаа холбоотой ажилд ороход үйлчилнэ.

Жишээ нь Систем инженер, Хими эмийн бүтээгдэхүүний судалгаа, Орчуулагч, Борлуулалт, Гадаад хэлний багш, Нягтлан бодогч зэрэг ажлын байрууд.

Техник технологи Хүмүүнлэг Олон улсын үйл ажиллагаа гэсэн үндсэн ажилтны визийг мэдүүлэх гадаадын иргэн нь доорх салбарын аль нэг мэргэжил эзэмшсэн байх ёстой бөгөөд Япон иргэнтэй ижил буюу түүнээс дээш цалин авна.

• Техник технологи Байгалийн шинжлэх ухаан

Мэргэжлийн салбар

Математик, Физик, Хими, Биологи, Газарзүй, Шинжлэх ухааны боловсрол, Статистик судлал, Мэдээлэл харилцаа, Техник, Механик судлал, Цахилгаан электроник, Барилга, Аркетуктер, Хэрэглээний хими, Байгалийн баялаг ашиглалт, Хөдөө аж ахуй, Малын эмч, Хүний эмч, Шүдний эмч, Эм зүйч гэх мэт.

• Хүмүүнлэгийн салбар

Хэл судлал, Соёл судлал, Философи, Биений тамир, Сэтгэлзүй, Нийгэм судлал, Түүх судлал, Дэлхий судлал, Хууль, Олон улс судлал, Иргэний хууль, Нийгмийн хууль, Улс төр судлал, Эдийн засгийн онол, Эдийн засгийн бодлого, Олон улсын эдийн засаг, Эдийн засгийн түүх, Хөрөнгө санхүү, Худалдаа, Бизнесийн удирдлага, Нягтлан бодох гэх мэт.

• Олон улсын үйл ажиллагаа

Бичгийн орчуулга, аман орчуулга, Хэлний багш, Зар сурталчилгаа, Гадаад худалдааны үйл ажиллагаа, Хувцас болон интерьер дизайн гэх мэт.

Доорх шаардлагын аль нэгийг хангасан байна.

1. Мэргэжлээрээ их сургуулийн бакалавр эсвэл түүнээс дээш боловсрол эзэмшсэн байх.
2. Мэргэжлээрээ Япон мэргэжлийн коллежид суралцсан байх.
3. 10 жилээс дээш мэргэжлээрээ ажилласан байх. Суралцсан хугацаа тооцогдоно

Бүрдүүлэх материал

1. Ажилд авах байгууллага нь гадаадаас ажилтан авах тохиолдол тухайн компани Гадаад хэргийн салбар агент дээр мэдүүлнэ. Уг салбар агентаас зөвшөөрвөл Оршин суух зөвшөөрөл олгогдоно.

Хэрвээ Япон улсад оршин суудаг ажил горилогч нь шинээр Үндсэн ажилтны виз хүсэх, эсвэл дахин сунгах бол өөрийн биеэр хүсэлтээ мэдүүлнэ.

Гадаадаас ажилтан хүлээн авах тохиолдолд шаардагдах бичиг баримт

1. Оршин суух зөвшөөрөл хүсэх хүсэлт 1 хувь (在留資格認定証明書交付申請書)
(татах: <http://www.moj.go.jp/content/001290028.pdf>)
2. Цээж зураг 1хувь 4х3 хэмжээтэй, хүсэлт гаргахаас 3 сарын дотор авахуулсан байх
3. Хариу буцаах дугтуй 1 ш (返信用封筒)
4. Ажил горилогчийн их сургууль, мэргэжлийн сургуулийн диплом болон дүнгийн жагсаалт 1хувь
5. Паспортын хуулбар (パスポートのコピー)
6. Хөдөлмөрийн гэрээ (労働契約書)
7. Компанийн гэрчилгээ (履歴事項全部証明書)
8. Үйл ажиллагааны танилцуулга (企業案内)
9. Сүүлийн нэг жилийн тайлангийн хуулбар 1 хувь, шинэ үйл ажиллагаа хэрэгжүүлэх бол үйл ажиллагааны төлөвлөгөө 1 хувь (直近の決算書、企画書)

Зөвшөөрөл олгоход шаардагдах хугацаа нь 1-3 сар орчим байдаг бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт материал бүрдүүлэх тохиолдол байдаг.

Хураамжгүй.

2. Оршин суух визээ өөрчлөх хүсэлтэй тохиолдолд шаардагдах бичиг баримт
Оршин суух эрхээ өөрчлөх хүсэлт нь жишээ нь Япон их дээд сургуульд суралцаж байсан гадаад оюутан Япон компанид ажилд орох тохиолдолд Гадаад оюутны визээ Үндсэн ажилтны визээр солихын тулд Гадаад иргэдийн салбар агент луу хүсэлт гаргах шаардлагатай.

1. Оршин суух виз өөрчлөх хүсэлт 1 хувь (在留資格認定証明書交付申請書)
(татах: <http://www.moj.go.jp/content/001290028.pdf>)
2. Цээж зураг 1хувь (4смх3см хэмжээтэй, хүсэлт гаргахаас 3 сарын дотор авахуулсан байх)
3. Хариу буцаах дугтуй 1 ш (返信用封筒)

4. Ажил горилогчийн их сургууль, мэргэжлийн сургуулийн диплом болон дүнгийн жагсаалт 1хувь (卒業証明書、成績証明書)
5. Паспорт болон Оршин суугчийн үнэмлэх (パスポートまたは在留カード)
6. Хөдөлмөрийн гэрээ (労働契約書)
7. Компанийн гэрчилгээ (履歴事項全部証明書)
8. Үйл ажиллагааны танилцуулга (企業案内)
9. Сүүлийн нэг жилийн тайлангийн хуулбар 1 хувь (直近の決算書)

Зөвшөөрөл олгоход шаардагдах хугацаа нь долоо хоногоос 1 сар орчим зарцуулагддаг бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт материал бүрдүүлэх тохиолдол байдаг. Хураамж 4000 иен байна.

3. Оршин суух визээ дахин сунгуулахад шаардагдах бичиг баримт

Оршин суух виз-ний хугацаа нь хэтэрсэн тохиолдолд хууль бус оршин суугч болох эрсдэлтэй тул виз-ний хугацаагаа дуусахаас өмнө дахин сунгуулах шаардлагатай.

1. Оршин суух виз сунгах хүсэлт 1 хувь (在留資格認定証明書交付申請書)
(татах: <http://www.moj.go.jp/content/001290028.pdf>)
2. Цээж зураг 1хувь 4x3 хэмжээтэй, хүсэлт гаргахаас 3 сарын дотор авахуулсан байх
3. Хариу буцаах дугтуй 1 ш (返信用封筒)
4. Ажлын байрны тодорхойлолт (在職証明書)
5. Паспорт болон Оршин суугчийн үнэмлэх (パスポートまたは在留カード)
6. Компанийн сүүлийн нэг жилийн тайлангийн хуулбар (直近の決算書)
7. Оршин суух татварын гэрчилгээ эсвэл татвар төлсөн баримт 1 хувь (住民税または所得税の納税証明書)

Виз мэдүүлэхэд шаардлагатай бичиг баримт нь тухайн орон нутгийн Гадаад иргэдийн салбар агентаас шалтгаалан өөр өөр байх ба 2 долоо хоногоос 1 сарын хугацаа шаардагдана. Хураамж 4000 иен байна.